



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ДАРХАН ДУЛААНЫ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2025/2/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Дархан-Уул аймаг
2025 он

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор Б.Алтанзул

Утас: 70378845 Цахим хаяг: altanzulby@audit.gov.mn

Аудитор З.Мөнгөнцэцэг

Утас: 70378845 Цахим хаяг: munguntsetsegz@audit.gov.mn

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Компани, түүний үйл ажиллагаа	11
3.2 Компанийн гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	11
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ДЭХ	Дулааны эрчим хүч
ДХЦЭХ	Дотоод хэрэглээний цахилгаан эрчим хүч
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЗБАХ	Техник зохион байгуулалтын арга хэмжээ
ХНН	Хувь нийлүүлсэн нийгэмлэг
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ЦЭХ	Цахилгаан эрчим хүч
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.05.14 № 150

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлого, мөнгөн гүйлгээ, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд үйл ажиллагааны бус орлогыг 268.5 хувиар биелүүлснээр төлөвлөсөн алдагдал 2,015,525.6 мянган төгрөгөөр буурч 428,765.1 мянган төгрөгийн алдагдал бүртгэж, санхүүгийн тайланд тодруулж толилуулсан байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 720 дугаар тогтоолоор ДЭХ-ний ахуйн хэрэглэгчдийн үнэ тарифт өөрчлөлт орж, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4525020238

Эрчим хүчний сайдын 2024 оны А/18 дугаар тушаалаар баталсан бизнес төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх захирлын 2024 оны А/68 тоот тушаалаар нийт ажиллагсдын цалинг 10 хувиар нэмэгдүүлэн, 2024 оны 7 дугаар сарын 1-ээс олгосон байна. Мөн гүйцэтгэх захирлын 2024 оны А/95 тоот тушаалаар ажиллагсдын үндсэн болон тарифт цалингийн хэмжээг шинэчлэн тогтоож, 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Компанийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 23 зорилтын хүрээнд 94 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, 3 ажил үргэлжлэн хэрэгжих шатандаа, ТЗБАХ-аар 1 ажил тодотгосон төлөвлөгөөгөөр хасагдаж, ХО-аар 1 ажил нэмэгдэж, гүйцэтгэлийг 96.8 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.МӨНХБАЯР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан


(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	572,843,066.96	325,523,315.24
1.1.2	Дансны авлага	603,450,418.55	615,813,321.60
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	58,015,674.11
1.1.4	Бусад авлага	130,088,788.15	316,130,255.15
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	
1.1.6	Бараа материал	624,698,871.96	614,467,772.76
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	33,469,471.92	6,794,487.20
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,964,550,617.54	1,936,744,826.06
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	23,859,539,981.91	23,326,906,411.19
1.2.2	Биет бус хөрөнгө	1,026,811,128.72	1,026,453,702.32
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	24,886,351,110.63	24,353,360,113.51
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	26,850,901,728.17	26,290,104,939.57
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	165,730,242.60	67,035,392.71
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	75,044,977.82	526,880.28
2.1.1.4	НДШ-ийн өглөг	10,223,775.54	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	449,000,000.00	470,000,000.00
2.1.1.6	Хүүний өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	111,731,553.75	110,166,603.96
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	811,730,549.71	647,728,876.95
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	811,730,549.71	647,728,876.95
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	17,920,722,852.44	17,920,722,852.44
2.3.2	Өмч: - хувийн	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,915,919,985.26	2,915,919,985.26
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	2,811,702,550.80	2,843,672,550.80
2.3.9	Хуримтлагдсан ашиг	2,390,825,789.96	1,962,060,674.12
2.3.11	Эздийн өмчийн дүн	26,039,171,178.46	25,642,376,062.62
2.4	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	26,850,901,728.17	26,290,104,939.57

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
01	Борлуулалтын орлого (цэвэр)	13,256,395,365.16	15,582,340,067.87
02	Борлуулалтын өртөг	7,389,980,443.70	9,020,438,753.79
03	Нийт ашиг (алдагдал)	5,866,414,921.46	6,561,901,314.08
04	Түрээсийн орлого	1,944,000.00	1,944,000.00
05	Хүүний орлого	173,439.13	5,268,802.84
06	Ногдол ашгийн орлого	-	-
07	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
08	Бусад орлого	1,479,159,331.21	1,977,225,637.38
09	Борлуулалт, маркетингийн зардал	3,007,461,498.76	3,715,240,396.45
10	Ерөнхий ба удирдлагын зардал	3,799,339,740.65	4,238,598,754.28
11	Санхүүгийн зардал	76,278,024.32	72,333,070.55
12	Бусад зардал	570,330,494.94	714,008,737.08
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(8,000,000.00)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	268,585,683.02	(226,397,031.50)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(374,303,749.89)	(428,238,235.56)
19	Орлогын татварын зардал	17,343.91	526,880.28
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(374,321,093.80)	(428,765,115.84)
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(374,321,093.80)	(428,765,115.84)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	-	-
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-



2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	17,920,722,852.44	-	2,915,919,985.26	2,802,982,550.80	2,765,146,883.76	26,039,171,178.46
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	17,920,722,852.44	-	2,915,919,985.26	2,802,982,550.80	2,765,146,883.76	26,404,772,272.26
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	8,720,000.00	-	8,720,000.00
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	(374,321,093.80)	(374,321,093.80)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн	-	-	-	-	-	-
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,920,722,852.44	-	2,915,919,985.26	2,811,702,550.80	2,390,825,789.96	26,039,171,178.46
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өөрчлөлт	-	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	17,920,722,852.44	-	2,915,919,985.26	2,811,702,550.80	2,390,825,789.96	26,039,171,178.46
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	31,970,000.00	-	31,970,000.00
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	(428,765,115.84)	(428,765,115.84)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн	-	-	-	-	-	-
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,920,722,852.44	-	2,915,919,985.26	2,843,672,550.80	1,962,060,674.12	25,642,376,062.62



2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	15,705,395,670.50	18,869,809,856.45
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	14,809,882,175.01	17,297,239,208.87
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
	Буцаан авсан албан татвар	17,066.47	526,880.28
	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
	Бусад мөнгөн орлого	895,496,429.02	1,572,043,767.30
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	15,103,959,292.74	18,526,680,761.01
	Ажиллагчдад төлсөн	4,250,974,454.81	5,390,013,792.10
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,477,452,401.00	1,845,880,000.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	5,535,237,056.68	6,857,556,548.58
	Ашиглалтын зардалд төлсөн	552,426,126.75	495,450,266.40
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	138,539,691.40	152,479,715.20
	Хүүний төлбөрт төлсөн	76,278,024.32	72,333,070.55
	Татварын байгууллагад төлсөн	1,266,071,189.76	1,783,679,483.43
	Даатгалын төлбөрт төлсөн	10,358,021.00	10,427,804.00
	Бусад мөнгөн зарлага	1,796,622,327.02	1,918,860,080.75
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	601,436,377.76	343,129,095.44
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	173,439.13	5,268,802.84
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
	Хүлээн авсан хүүний орлого	173,439.13	5,268,802.84
	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
	Бусад	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	479,280,275.98	616,717,650.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	390,370,675.98	603,847,650.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	88,909,600.00	12,870,000.00
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
	Бусдад олгосон зээл болон урьдчилга	-	-
	Бусад	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(479,106,836.85)	(611,448,847.16)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,554,192,543.06	1,825,021,178.18

	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	2,554,192,543.06	1,825,021,178.18
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	
	Төрөл бүрийн хандив	-	
	Бусад	-	
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,448,132,543.06	1,804,021,178.18
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	2,448,132,543.06	1,804,021,178.18
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	
	Төлсөн ногдол ашиг	-	-
	Бусад	-	
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	106,060,000.00	21,000,000.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	228,389,540.91	(247,319,751.72)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	344,453,526.05	572,843,066.96
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	572,843,066.96	325,523,315.24



2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он	2024 он				
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
1	Худалдан авсан дулаан	мян.Гкал	647.4	664.3	678.8	14.5	2.2	
	Үүнээс:	Уураар	мян.Гкал	15.5	12.8	16.7	4.0	31.1
		Уураар	мян.Гкал	631.9	651.5	662.1	10.5	1.6
	Худалдаж авсан ДЭХ-ний өртөг	мян.төг	4,050,082.4	4,941,201.0	4,968,088.6	26,887.6	0.5	
	ДЭХ-ний алдагдал	хувиар	хувь	15.29%	15.29%	15.26%	(0.0)	(0.2)
		биетээр	мян.Гкал	96.6	101.6	101.0	(0.6)	(0.6)
Борлуулах дулааны эрчим хүч	мян.Гкал	550.8	562.7	577.7	15.1	2.7		
2	Нийт орлого	сая төг	14,737,672.2	15,476,448.3	17,566,778.5	2,090,330.3	13.5	
	Үүнээс:	Борлуулалтын орлого	мян.төг	13,256,395.4	14,937,911.2	15,582,340.1	644,428.8	4.3
		ажиллагааны бус орлого	мян.төг	1,481,276.9	538,537.0	1,984,438.4	1,445,901.4	268.5
Борлуулалтын орлого цуглуулалт	мян.төг	13,222,391.3	14,937,911.2	8,334,372.7	(6,603,538.5)	(44.2)		
3	Нийт зардал	мян.төг	15,111,975.9	17,920,739.0	17,995,016.7	74,277.8	0.4	
	Үүнээс:	Үйл ажиллагааны зардал	мян.төг	10,308,261.4	12,658,307.4	12,181,326.8	(476,980.6)	(3.8)
		Худалдаж авсан ДЭХ-ний өртөг	мян.төг	4,050,082.4	4,941,201.0	4,968,088.6	26,887.6	0.5
		Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	753,632.1	321,230.6	845,601.3	524,370.7	163.2
	ҮХЭ-ийн зардал	мян.төг	1,796,761.2	1,910,407.8	1,824,886.6	(85,521.2)	(4.5)	
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	(374,303.7)	(2,444,290.7)	(428,238.2)	2,016,052.5	(82.5)	
5	Татварын дараах ашиг /алдагдал/	мян.төг	(374,321.0)	(2,444,290.7)	(428,765.1)	2,015,525.6	(82.5)	
6	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	мян.төг	1.025	1.158	1.024	(0.134)	(11.534)	
7	Нийт авлага	мян.төг	733,539.2	1,014,113.0	989,959.3	(24,153.7)	(2.4)	
	Үүнээс:	Борлуулалтын авлага	мян.төг	592,677.3	1,009,313.0	613,033.0	(396,280.0)	(39.3)
		Бусад	мян.төг	140,861.9	4,800.0	376,926.2	372,126.2	7,752.6
8	Нийт өглөг	мян.төг	811,730.5	1,007,026.8	647,728.9	(359,298.0)	(35.7)	
	Үүнээс:	УХӨТ	мян.төг	-	-	-	-	-
		БХӨТ	мян.төг	811,730.5	1,007,026.8	647,728.9	(359,298.0)	(35.7)
9	Нийт ажиллагсад	мян.төг	191	191	189	(2.0)	(1.0)	
10	Нийт цалингийн сан	мян.төг	5,286,140.3	6,785,515.5	6,736,391.6	(49,123.9)	(0.7)	
11	Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт	мян.төг	1,054,090.0	1,656,527.7	1,379,928.0	(276,599.8)	(16.7)	
	Үүнээс:	Их засвар	мян.төг	734,540.0	1,060,432.0	815,160.0	(245,272.0)	(23.1)
		ТЗБАХ	мян.төг	125,120.0	294,687.3	273,628.5	(21,058.8)	(7.1)
		Хөрөнгө оруулалт	мян.төг	194,430.0	301,408.5	291,139.5	(10,269.0)	(3.4)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

“Дарханы дулааны сүлжээ” ТӨХК нь Эрчим хүчний зохицуулах хорооноос олгосон “Дулаан түгээх”, “Дулаанаар зохицуулалттай хангах” тусгай зөвшөөрлийн хүрээнд 7 зуух, 5 турбин, сүлжээний 3 насос, дамжуулах сүлжээний 2 насос станц, 14 дулаан хуваарилах төвөөр дамжуулан Дархан сумын төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон айл өрх, ААНБ-уудыг дулааны эрчим хүчээр хангах үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Эрчим хүчний тухай хууль, Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль эрхийн актыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай, Эрчим хүчний тухай зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

Хяналтын хэлтэс нь 2024 онд 20 ажил төлөвлөснөөс санхүүгийн чиглэлээр 2 ажлын төлөвлөгөө боловсруулж гүйцэтгэх захирлаар батлуулан, илэрсэн зөрчлийг тухай бүр арилгуулж, хэрэгжилтийг тооцсон байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 11 дүгээр тогтоолоор компанийн зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт оруулж, 06, 07, 08 дугаар тогтоолуудаар ТУЗ-ын төрийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүд, хараат бус гишүүдийг, 15 дугаар тогтоолоор нарийн бичгийн даргыг өөрчлөн томилсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг гүйцэтгэх захирлын 2019 оны А/68 дугаар тушаалаар баталж, мөн оны 01 дүгээр сараас мөрдөж эхэлсэн бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Дарханы дулааны сүлжээ” ТӨХК -ийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 560,796.8 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	572,843.1	325,523.3	(247,319.80)
Дансны авлага	603,450.4	615,813.3	12,362.90
Татвар, НДШ-ийн авлага	-	58,015.6	58,015.70
Бусад авлага	130,088.8	316,130.2	186,041.40
Бараа материал	624,698.8	614,467.7	(10,231.00)
Урьдчилж төлсөн зардал тооцоо	33,469.8	6,794.5	(26,675.30)
Үндсэн хөрөнгө	23,859,539.9	23,326,906.4	(532,633.50)
Биет бус хөрөнгө	1,026,811.2	1,026,453.7	(357.50)
Нийт хөрөнгө	26,850,901.7	26,290,104.9	(560,796.80)
Богино хугацаат өр төлбөр	811,730.5	647,728.80	(164,001.70)
Урт хугацаат өр төлбөр	-	0	-
Эздийн өмчийн дүн	26,039,171.2	25,642,376.10	(396,795.10)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	26,850,901.7	26,290,104.90	(560,796.80)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 247,319.8 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн бус үйл ажиллагааны орлого 1,984,438.4 мянган төгрөг төвлөрөхөөс гэрээт ажлын санхүүжилт дутуу орсноос шалтгаалсан байна.

Авлага дансны үлдэгдэлд гэрээт ажлын авлага 311,157.5 мянган төгрөг, алдангийн авлага 4,147.5 мянган төгрөг, ХХОАТ-ын авлага 44,195.9 мянган төгрөг, НДШ-ийн авлага 13,819.7 мянган төгрөг, иргэн, аж ахуй нэгж байгууллагаас авах дулааны төлбөр, бусад авлага 616,638.5 мянган төгрөгийн үлдэгдэл тус тус эзэлж байна. Нийт авлагын 62.2 хувийг борлуулалтын авлага эзэлж байна.

Бараа материал дансны үлдэгдэл өмнөх оноос 10,231.0 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар буурсан байна.

Урьдчилж төлсөн зардал данс 26,675.3 мянган төгрөгөөр буюу 20.3 хувиар буурсан нь "Одкон холдинг" ХХК дулааны магистрал шугам сүлжээний зураг төслийн үнийн үлдэгдлийг төлж, тооцоог хаасантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө данс 532,633.5 мянган төгрөгөөр буюу 2.2 хувиар буурсан нь ТӨБЗГ-ын 2024 оны 507 дугаар тогтоолоор 234,019.2 мянган төгрөгийн шугам хоолойг акталж, 1,893,373.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 1,965,740.2 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан нь хөрөнгийн бууралтад нөлөөлсөн байна.

Богино хугацаат өглөгийн дансны үлдэгдэлд худалдан авсан дулааны эрчим хүчний 11,341.1 мянган төгрөг, бусад байгууллагад төлөх 40,194.2 мянган төгрөг, татварын өр 526.9 мянган төгрөг, банкны богино хугацаат зээл 470,000.0 мянган төгрөг, 110,166.6 мянган төгрөгийн урьдчилж орсон орлого байна.

Богино хугацаат өр төлбөр 164,001.7 мянган төгрөгөөр буюу 20.2 хувиар буурсан нь Дархан Дулааны Цахилгаан Станц ХК-д төлөх өглөгийг хугацаанд нь төлж 100,217.1 мянган төгрөгөөр, татварын өглөгийг 74,518.0 мянган төгрөгөөр, хувь хүмүүст өгөх өглөгийг 13,499.9 мянган төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Эздийн өмчийн дүн 25,642,376.1 мянган төгрөг болж 396,795.1 мянган төгрөгөөр буурахад тайлант үеийн алдагдал голлон нөлөөлжээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК нь компанийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/18 тоот тушаалаар компанийн 2024 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 14,123,900.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 17,920,700.0 мянган төгрөгөөр, 3,796,800.0 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар тооцсон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 1,675,000.0 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Эрчим хүчний сайдын 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/177 дугаар тушаалаар тодотгол хийж, орлогыг 1,352.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 15,476,400.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг өөрчлөхгүйгээр 17,920,700.0 мянган төгрөгөөр, 2,444,300.0 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар тодотгосон байна. Харин хөрөнгө оруулалтын арга хэмжээний зардлыг 1,656,500.0 болгож бууруулсан байна.

Гүйцэтгэлээр 17,566,778.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 17,995,016.7 мянган төгрөгийн зардал гарган, 428,765.1 мянган төгрөгийн татварын дараах алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын төлөвлөгөөг 2,090,330.3 мянган төгрөгөөр буюу 13.5 хувиар давуулан биелүүлсэн байна. Энэ нь борлуулалтын орлого 644,428.8 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны бус орлого 1,445,901.4 мянган төгрөгөөр давж биелсэнтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 17,995,016.7 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 74,277.8 мянган төгрөг буюу 0.4 хувиар хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ нь үйл ажиллагааны бус зардал хэтэрсэнтэй холбоотой байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 46 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 1,379,928.0 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант оны төлөвлөгөөгөөр 2,444,290.7 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 428,765.1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь үндсэн бус үйл ажиллагааны орлого төлөвлөгөөнөөс давсантай холбоотой байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн цалингийн зардал, Шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Алтанзул, З.Мөнгөнцэцэг нар гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

“Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 1/191 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан зардлын 17,920,730.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 179,207.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар тодорхой ажил зохион байгуулж ажилласан байна. Ашиглалтын зардал буюу цахилгааны зардлаас 93,052.6 мянган төгрөг, бичиг хэргийн зардлаас 2,190.6 мянган төгрөгийг тус тус хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 62,818.8 мянган төгрөгийн 5 гүйлгээ, бусад төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой

71,785.8 мянган төгрөгийн 14 тушаал, шийдвэрийг байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалттай нийцэхгүй байгаа тул Шилэн дансны нэгдсэн системд байршуулаагүй 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 62,818.8 мянган төгрөгийн 5 гүйлгээ, бусад төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 71,785.8 мянган төгрөгийн 14 тушаал, шийдвэрийг нөхөн байршуулж, алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 116,661.9 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 4,813.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчил арилгуулах 101,465.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 10,383.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	4,813.9	1	4,813.9	100.0
Албан шаардлага	1	101,465.0	1	101,465.0	100.0
Зөвлөмж	1	10,383.0	1	10,383.0	100.0
Нийт дүн	3	116,661.9	3	116,661.9	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 14,015.9 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэн тул 14,015.9 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт, зөрчлийн арилгах 1 зөвлөмжийг хүргүүллээ. Аудитын явцад 800.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг барагдуулсан.

5.1 Төлбөрийн акт

- Компанийн 7 ажилтанд жилийн үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлсийг 11,608.8 мянган төгрөгөөр давхардуулан олгосон нь Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 7 дугаар тогтоолоор баталсан *"Компанийн ажилтнуудад 2023 оны жилийн үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох тухай"*, Гүйцэтгэх захирлын 2024 оны Б/55 дугаар тушаалаар баталсан *"Жилийн үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох тухай"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д *"Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна"* гэж заасантай тус тус нийцээгүй тул төлбөрийн акт тогтоов.

- Дулаан дамжуулах албаны тоноглолын засварчин П.Ганбаатарын цалингаас сахилгын шийтгэлийн 20 хувь болох 412.7 мянган төгрөгийг суутгаагүй нь Компанийн гүйцэтгэх захирлын 2024 оны Б/22 дугаар тушаалаар баталсан *"Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулж, үндсэн цалинг 3 сараар 20 хувиар бууруулах"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д *"дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"* гэж заасантай тус тус нийцээгүй тул төлбөрийн акт тогтоов.

- Компанийн ажилтнуудын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийсэн "ХЭЛТ РӨҮД" ХХК-ний гэрээт ажлын гүйцэтгэлийг хянахад 800.0 мянган төгрөг илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно."*, 13.6-д *"Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна"*, *"Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийх"* 105/2024 тоот гэрээний 4 дүгээр зүйлийн 4.3-т *"Гэрээний эцсийн дүнг үзлэг шинжилгээнд хамрагдсан ажилтны тооны гүйцэтгэлээр дүгнэнэ"* гэсэн заалттай, санхүүгийн тайлангийн *"нийцсэн бөгөөд зохистой байх"* батламж мэдэгдлийг хангаагүй тул төлбөрийн акт тогтоосныг аудитын явцад барагдуулсан.

- Салбарын хяналтын ажилтны зөвлөгөөн зохион байгуулахдаа анхан шатны баримтын бүрдэлгүй 1,194.5 мянган төгрөгийн зардал гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно."*, 13.6-д *"Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна"*, 18.1-д *"Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ"* гэж заасантай тус тус нийцээгүй тул төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Санхүүгийн тайлагналтай холбоотой албан шаардлага өгөөгүй.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Тус компани нь гүйцэтгэх захирлын 2023 оны А/33 дугаар тушаалаар баталсан “ДДС” ТӨХК-ийн орлогын байцаагч нарын ажлыг дүгнэх, авлага барагдуулах чиглэлээр урамшуулал олгох журам”-аар борлуулалтын байцаагч нарт сарын үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлсийг 6,107.4 мянган төгрөгөөр илүү олгосон нь гүйцэтгэх захирлын 2022 оны А/56 дугаар тушаалаар баталсан “ДДС ТӨХК-ийн ажилтнуудад сарын ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох журам”-тай нийцэхгүй байна.

Тус компанийн борлуулалтын байцаагч нарын сарын үйл ажиллагааны үр дүнг гүйцэтгэх захирлын 2023 оны А/33 дугаар тушаалаар баталсан “ДДС ТӨХК-ийн орлогын байцаагч нарын ажлыг дүгнэх, авлага барагдуулах чиглэлээр урамшуулал олгох журам”-аар үнэлж 50-55 хувиар олгосон байна. Энэхүү журам нь гүйцэтгэх захирлын 2022 оны А/56 дугаар тушаалаар баталсан “ДДС ТӨХК-ийн ажилтнуудад сарын ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох журам”-ын 2.2, 2.4-д заасан хувь хэмжээтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

“Борлуулалтын орлогын байцаагч нарын ажлыг дүгнэх, авлага барагдуулах чиглэлээр урамшуулал олгох журам”-ыг “Компанийн ажилтнуудад сарын ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох журам”-тай уялдуулж, өөрчлөлт оруулах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасны дагуу ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² 20.5. Шалгаагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Запруулсан		Запруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

(мянган төгрөгөөр)

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалт-ны тоо	Тоо	Дүн
Компанийн 7 ажилтанд жилийн үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлсийг 11,608,800.0 төгрөгөөр давхардуулан олгосон Дулаан дамжуулах албаны тоноглолын засварчин П.Ганбаатарын цалингаас сахилгын шийтгэлийн 20 хувь болох 412,713.0 төгрөгийг суутгаагүй	1	11,608.8	1	11,608.8	-	-	-	-	-	-	-	-
Ажилчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг гүйцэтгэсэн "ХЭЛТ РӨҮД" ХХК-ний гэрээт ажлын гүйцэтгэлийг хянахад 800,000.00 төгрөг илүү олгосон	1	412.7	1	412.7	-	-	-	-	-	-	-	-
Салбарын хяналтын ажилтны зөвлөгөөн зохион байгуулахдаа анхан шатны баримтын бүрдэлгүй 1,194,480.00 төгрөгийн зардал гаргасан	1	800.0	1	800.0	-	-	-	-	-	-	-	-
Компанийн борлуулалтын байцаагч нарын сарын үйл ажиллагааны үр дүнг гүйцэтгэх захирлын 2023 оны А/33 дугаар тушаалаар баталсан "ДДС ТӨХК-ийн орлогын байцаагч нарын ажлыг дүгнэх, авлага барагдуулах чиглэлээр урамшуулал олгох журам"-аар үнэлж 50-55 хувиар олгосон байна.	1	1,194.5	1	1,194.5	-	-	-	-	-	-	-	-
Дүн	5	14,015.9	4	14,015.9	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо		Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 62,818.8 мянган төгрөгийн 5 гүйлгээ, бусад төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 71,785.8 мянган төгрөгийн 14 тушаал, шийдвэрийг байршуулаагүй	1	134,604.6	-	-	-	-	1	134,604.6
Дүн	1	134,604.6	-	-	-	-	1	134,604.6
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн								